

3.Хорих ял эдлүүлэх ажиллагааг ялын зорилгыг хангахад бүрэн чиглүүлэхэд эрх зүйн зохицуулалт, хэрэгжүүлэгч байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, менежментийг сайжруулах гэсэн саналыг дэвшүүлж байна.

**Б.ХИШИГЖАРГАЛ**

Булган аймаг дахь  
Шүүхийн шийдвэр  
гүйцэтгэх албаны ахлах  
шийдвэр гүйцэтгэгч,  
хошууч

### **ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь нэг талаас ихээхэн нягт нямбай, шударга ажиллагаа нөгөө талаас ихээхэн зардал шаардсан түвэгтэй ажил байдаг.<sup>97</sup>

Энэхүү харилцаанд оролцогчдын үйлдэл бүр эцсийн бүлэгтээ мөнгө, төсөв зайлшгүй гарах зардалтай холбогддог. Үүнийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал хэмээх нэр томъёогоор илэрхийлж ойлгодог байна. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдон гарах зардлыг ерөнхийд нь 3 хэсэгт бүлэглэж ангилан авч үзэж болно<sup>98</sup>. Үүнд:

1. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зайлшгүй гарах зардал
2. Шийдвэрийг бодитойгоор гүйцэтгэсэн тохиолдолд шийдвэр гүйцэтгэгчид урамшууллын хэлбэрээр олгогдох зардал
3. Гүйцэтгэгдсэн шийдвэрийг цуцлахтай холбогдсон зардал хамаарна.

Шийдвэр гүйцэтгэгч нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг тухай бүр төлбөр авагчаас урьдчилан гаргуулж шийдвэр гүйцэтгэх албаны дансанд төвлөрүүлнэ.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг хүлээн авах болон албаны

<sup>97</sup>А.Лхагва “Монгол улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй” УБ хот, 2008 он, 186 дахь тал

<sup>98</sup>Б.Дашзэвэг “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй” УБ хот, 2003 он 200 дахь тал

дансанд төвлөрүүлэх, төлбөр авагчид буцаан олгох зэрэг баримтууд нь нэгдсэн дугаартай хэвлэмэл маягт байх бөгөөд засваргүй бичигдсэн байх шаардлага тавигдана. Гүйцэтгэх баримт бичиг нь хүчингүй болсонд тооцогдсоны улмаас шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсон тохиолдолд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулсаны зардлыг улсын төсвөөс гаргана.

### **Зардлын талаарх уламжлал:**

Иргэн, хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагаа 1926 оноос эхлэн шүүхийн харъяанд байгаад 1996 оноос хорих байгууллагатай нэгдсэн тул зардлын тухай эх сурвалж нь Шүүхийн зохион байгуулалтын тухай хууль /1949 он/, Иргэний байцаан шийтгэх хууль /1967 он/, Шүүхийн байгууллагын тухай хууль /1978 он/, БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн заавар /1985он/, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль байгууллагын тухай хуулиудад тусгалаа олсон байна.

1926 онд батлагдсан Монгол ард улсын шүүх таслах газруудад аливаа хэргийг байцаах шийтгэх тухай хуулиас: .....Данслан битүүмжилсэн хөрөнгө хогшлын зүйлийг түр хадгалахаар хүлээн авсан хүн өртөн этгээдээс өөр хүн болох бол тусгай хөлс олговол зохих бөгөөд түүний хэмжээг уул юмны эзэн ба өр нэхэмжилсэн этгээдтэй харилцан хэлэлцэж тогтоовол зохих авч, хэрэв үл тохирвол харьяат шүүх таслах газраас орон нутгийн байдал ба зүй зохисыг нь үзэж шийтгэл тогтооно. Дээрхи зүйлүүдэд заасан хөрөнгө хогшлын зүйлийг түр хадгалахаар хүлээн авсан хүн нь уул юмны эзэн өөрөө болох бөгөөд хадгалсан зүйлүүдэд гэж шийтгэл гарахгүй бол хувьдаа хэрэглэж болдог байсан байна.

1952-он БНМАУ-ын иргэний байцаан шийтгэх хуулиас: .....Хадгалагч хүн нь өр төлөгч этгээд биш бол хадгалсны шагналыг ардын шүүхийн

тогтоосон ёсоор авч, хадгалж байсан шагналыг уул хөрөнгө хогшлыг худалдан борлуулсан мөнгөнөөс олгодог байжээ. Хэрвээ барьцаа хөрөнгө худалдсан нөхцөлд уул хөрөнгийг барьж авах, хадгалах ба түүнийг худалдахад зориулсан зардлыг төлөөд бусад үлдсэн мөнгөнөөс төлбөрийг төлүүлдэг байсан байна. 1967-он БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хууль: Шийдвэр гүйцэтгэх үед төлбөр төлөгчийн эд хөрөнгийг хадгалах, тээвэрлэх, худалдах хийгээд шинжээчид төлөх төлбөр, мөн шүүхийн тогтоол гүйцэтгэгч уг шийдвэрийг гүйцэтгэх газар хүрэлцэн ирсний зардлыг шүүхийн тогтоол гүйцэтгэгчийн харьяалагдах шүүхийн төсвөөс гаргадаг байсан бөгөөд энэхүү зардлыг төлбөр төлөгчөөс шийдвэр гүйцэтгэхэд эд хөрөнгө буюу мөнгө гаргуулсныг харгалзахгүй шүүгчийн магадлалаар улсын орлогод буцаан төлүүлдэг байжээ. Энэ тухай шүүгчийн магадлалд энгийн гомдол гаргах буюу эсэргүүцэл бичиж болдог байсан байна.

1996-он. Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль: Шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэх ажиллагааны бүх зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх бөгөөд эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах, хураах, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэх, худалдан борлуулах, нуусан эд хөрөнгийг илрүүлэх ажиллагааны зардлыг төлбөр төлөгчөөс нөхөн гаргуулж, шийдвэр биелүүлэх байгууллагын дансанд оруулдаг байжээ.

2002 онд батлагдсан одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль нь 1998 онд УИХ-аас баталсан Монгол улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрт “Шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагааны зарчим, эрх зүйн үндсийг боловсронгуй болгож, цаашид өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зарчимд шилжих боломжийг судална” гэсэн заалтыг хэрэгжүүлэн шийдвэр

гүйцэтгэх ажиллагааны зардал, урамшууллын гэрээг байгуулдаг, дагасан журам баталдаг болсон байна. Шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг тухай бүр төлбөр авагчаас гаргуулж шийдвэр гүйцэтгэх албаны дансанд төвлөрүүлээд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсон тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг төлбөр төлөгчөөс нөхөн гаргуулж, төлбөр авагчид олгодог болсон байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуулийн 83 дугаар зүйлд “Шүүхийн шийдвэрийг бодитойгоор гүйцэтгэсэн шийдвэр гүйцэтгэгчийг төлбөрийн шаардлагыг хангахаар гаргуулсан мөнгөний болон эд хөрөнгийн үнийн дүнгийн 0,5-10 хүртэл хувиар урамшуулна”

Мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т “Шийдвэр гүйцэтгэгчийн цалингаас бусад үйл ажиллагааны зардлыг энэ хуулийн 83 дугаар зүйлд заасан урамшуулаас санхүүжүүлнэ” гэж тус тус заасан байдаг. Үүнээс харахад шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагааны зардлын санхүүжилтийн эх үүсвэрийг урамшуулаас гаргуулахаар харагдаж байгаа юм.

Гадаадын зарим оронд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг шийдвэрлэж буй эрх зүйн зохицуулалтын онцлог

**Оросын холбооны улс:** Шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг явуулах зардал нь гүйцэтгэх үйл ажиллагаанд оролцсон нэхэмжлэгч болон бусад этгээдээс гүйцэтгэх үйл ажиллагаа явуулах буюу зохион байгуулах, албадан гүйцэтгэх ажиллагаанд зарцуулсан, холбооны төсвийн мөнгөн хөрөнгө бөгөөд шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг явуулах зардлыг хариуцагчаас холбооны төсөв, нэхэмжлэгч болон заагдсан зардал гарсан бусад этгээдэд нөхөн төлнө.

Холбооны хуулинд гүйцэтгэх ажиллагааг зогсоосон тохиолдолд гүйцэтгэх үйл ажиллагаа явуулсан зардал нь холбооны төсөвт хамаардаг байна. Мөн шийдвэр гүйцэтгэгч нар нь бусад орон нутагт томилолтоор ажиллах тохиолдолд ямар нэгэн дараалал хүлээлтгүйгээр бүх төрлийн тээврийн хэрэгслээр зорчих тасалбар авах эрхтэй ба зочид буудалд үнэ төлбөргүй байрлах эрхтэй байдаг.

**Холбооны Бүгд Найрамдах Герман улсад:** Шийдвэр гүйцэтгэлийн явцад зайлшгүй зардал гарсан бол түүнийг төлбөр төлөгч хариуцана. Зардлыг шийдвэр гүйцэтгэлээр хэрэгжүүлж буй шаардлагын хамтаар гаргуулна. Шийдвэр гүйцэтгэлийн зардалд шүүхийн шийдвэрийг хувиан олшруулсан ба хүргүүлсэн зардал мөн адил багтана.

Хэд хэдэн үүрэг гүйцэтгэгч хамтран төлбөр төлөхөөр шүүхийн шийдвэр гарсан бол тэд шийдвэр гүйцэтгэлийн зардлыг хамтран хариуцана. Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны үндэслэл болсон шүүхийн шийдвэр хүчингүй болсон тохиолдолд шийдвэр гүйцэтгэлийн зардлыг төлбөр төлөгчид буцаан олгоно. Мөн онцгой шалтгааны улмаас төлбөр авагчийн нөхцөл байдлыг харгалзан үзэхэд тэнцвэртэй шударга байхаар бол шүүх зардлыг бүхэлд нь эсвэл зардлын тодорхой хэсгийг төлбөр авагчид хариуцуулж болно.

**Казахстан улсын тухайд:** Тус улсад шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь төрийн болон хувийн гэсэн 2 хэлбэрээр ажилладаг. Төрийн болон хувийн шийдвэр гүйцэтгэгчидийн эрх зүйн баталгааг шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нарын эрх зүйн байдал ба шийдвэр гүйцэтгэх журмын тухай хуульд ялгаатай зохицуулсан бөгөөд төрийн шийдвэр гүйцэтгэгчдийн бүтэц зохион байгуулалт, материал ба эд хөрөнгө, техник тоног

төхөөрөмжийн хэрэгцээт зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж төрөөс хангадаг ба шийдвэр гүйцэтгэгчдийн оршин суугаа газрыг нууцлах асуудлыг мөн хуульчилсан байна.

Хувийн шийдвэр гүйцэтгэгч нь эрх бүхий төрийн байгууллагаас шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаа явуулах эрхийг авсан хүмүүс байдаг ба тусгайлан хуулийн этгээд байгуулах шаардлагагүй байдаг. Хувийн шийдвэр гүйцэтгэгчид нь өөрт хандсан хувь хүн болон хуулийн этгээдийн эрх ашгийн төлөө шаардлагатай шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагааг явуулдаг ба үйл ажиллагаагаа явуулахтай холбоотой бүхий л зардлаа өөрсдөө хариуцдаг байна.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг бодит байдлаар тооцох зорилгоор зарим шийдвэр гүйцэтгэх албадын гаргасан зардлын тооцоог судлахад дунджаар 1 гүйцэтгэх баримт бичигт:

- Суурин газарт 130,000-480,000 орчим төгрөг

- Алслагдсан газарт 180,000-780,000 төгрөг байхаар тооцсон байх жишээтэй.

Гэхдээ энэ зардалд зөвхөн шууд зардал тооцогдсоноос шууд бус хувьсах зардлууд багтаагүй болно. Одоогийн эрх зүйн зохицуулалтаар талуудыг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлаас чөлөөлөх заалт байхгүй боловч шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад зарим гүйцэтгэлд зардал тогтоон гаргуулах боломжгүй байдаг тул энэ төрлийн гүйцэтгэх баримт бичигт ажиллагаа явуулахад багагүй хүндрэл бэрхшээл тулгарч байна.

#### Тулгамдаж буй асуудлууд:

Одоогийн үйлчилж байгаа урамшууллын гэрээг 0,5-10 хувь хүртэл төлбөр авагчтай байгуулдаг боловч үүнээс 0,3-3,5 хувь нь аймаг нийслэлийн шийдвэр гүйцэтгэлийн алба төлбөр авагчтай шүүхийн шийдвэрийг бодитойгоор гүйцэтгэсэн төлбөрийн шаардлагыг хангахаар гаргуулсан

мөнгөний болон эд хөрөнгийн үнийн дүнгийн 0,3-3,5 хувиар зардал тооцон суутгаж авч байна. Шүүхийн шийдвэрийг бодитойгоор гүйцэтгэсэн шийдвэр гүйцэтгэгчийг төлбөрийн шаардлагыг хангахаар гаргуулсан мөнгөний болон эд хөрөнгийн үнийн дүнгийн 0,2-6,5 хүртэлх хувиар урамшуулал авч байна.

1. Нэг гүйцэтгэх баримт бичигт гарах зардал тодорхой бус шийдвэр гүйцэтгэгч нар өөрсдийн үзэмжээр зардлыг тооцдог.
2. Хорихоос өөр төрлийн ялын гүйцэтгэх баримт бичгийн зардлыг хуулинд тодорхой тусгаагүй.
3. Төрийн байгууллагын нэхэмжлэлтэй гүйцэтгэх баримт бичгийн зардлыг тодорхой болгох
4. Бага үнийн дүнтэй гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг явуулахад төлбөрийн үнийн дүнгээс их зардал гарах тохиолдол гардаг
5. ИХШХШ тухай хуулийн 186 дугаар зүйлд заасны дагуу шийдвэр гүйцэтгэх алба шууд хүлээн авч байгаа гүйцэтгэх баримт бичигт гарах зардлыг тодорхой болгох. Тухайлбал: УТХ, ялтны төлбөрийн гүйцэтгэх баримт бичиг, Хөрөнгө хамгаалах захирамж г.м
6. Хорих ангид ял эдэлж байгаа ялтныг төлбөрийг барагдуулахад гарах зардлыг тухай бүр төлбөр авагчаас авах боломж муутай байдаг.
7. Хөдөө орон нутагт гүйцэтгэх баримт бичгийн тоо цөөн байдаг учраас зардал төвлөрөлт муу байдаг.

#### Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг зохицуулалтыг боловсронгуй болгох нь:

1. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зайлшгүй гарах зардлыг тооцох аргачлал бий болгохын зэрэгцээ ажиллагаа 1 бүрт тохирсон зардлын үнэлэмж бий болгох.
2. Хөдөө орон нутагт ажилладаг шийдвэр гүйцэтгэгч нарт томилолтын зардал, ажиллагааны зардлыг бүс нутгийн